

АЛБАН ТУШААЛТАНД ХАРИУЦЛАГА ТООЦОХ АСУУДЛЫГ ШҮҮН ХЭЛЭЛЦЭХ ХОЁР ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТЫН ЭРХ МЭДЭЛ

Д.Сүхболд

Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн ахлах багш

Хураангуй

Төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох (импичмент) асуудлыг шүүн хэлэлцэх хоёр танхимтай парламентын эрх мэдэл, хоёр танхимтай парламентын бүтцээр дамжуулж импичмент явуулдаг олон улсын практик, парламентын мөрдөн шалгах хороо зэргийн талаар өгүүлж, төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох тогтолцооны талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл ямар төвшинд байгааг судалж үзэв.

Онол, арга зүйн үндэслэл

Тус өгүүллэгийн онолын үндэслэл нь анх дундад зууны Английн сонгодог хоёр танхимтай парламентад үүссэн “импичмент”-ийн (зэмлэл) тогтолцоо юм. Тодруулбал Английн парламент нь төрийн өндөр албан тушаалтнуудыг хариуцлагад татах импичментийн шүүхийг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй байдаг. Энэ тохиолдолд Нийтийн танхим импичмент үүсгэх саналыг дэвшүүлж, Лордын танхим нь эцсийн шийдвэр гаргах шүүхийн үүрэг гүйцэтгэдэг.

Арга зүйн хувьд

Импичментийн онол сэтгэлгээний үндсийг тодруулж гаргахад түүхэн арга зүй, түүний олон улсад хэрэгжсэн туршлага, парламентын мөрдөн шалгах хороо зэрэг асуудлыг судлахад харьцуулах арга зүй, төрийн өндөр албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох механизмын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэлд хийсэн судалгаанд социологийн онолын болон эмпирик арга зүй ашиглагдав.

Удиртгал

Монголд төрийн өндөр дээд албан тушаалтнуудтай¹ холбоотой авилга, хээл хахуулийн шинжтэй хэргүүд олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байгаа бөгөөд хамгийн гол нь тэдэнтэй улс төрийн хариуцлага тооцох механизмгүй улмаас олон нийт зөвхөн шуугиад л өнгөрдөг эмгэнэлтэй байдал Монгол нэгэнт бий болоод байгааг бүгд бэлхнээ харж байна. Тухайлбал Чингис, Самурай бондын захиран зарцуулалтын асуудал, Оюутолгой болон Дубайн алдаатай гэрээ, 60 тэрбумын хэрэг, Эрдэнэтийн 49%-ийн асуудал, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас авсан УИХ-ын гишүүдийн зээл гэх мэт олон нийтийн бухимдлыг барсан олон асуудлуудад хариуцлага тооцох боломжгүй нөхцөл үүсээд байна.

¹ Төрийн өндөр албан тушаалтан гэдэгт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн дарга, Улсын ерөнхий прокурор, хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас томилогддог бусад албан тушаалтнууд багтана.

Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд зааснаар Монгол улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор нарыг Монгол улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл огцруулах, эргүүлэн татах асуудлыг Үндсэн хуулийн цэц хуралдаанаараа шийдвэрлэж, дүгнэлт гаргахаар² ерөнхий байдлаар зохицуулсан ч энэ нь хангалтгүй юм гэдгийг дээрх хариуцлага тооцох боломжгүй төрийн өндөр албан тушаалтнуудын холбогдсон хэргүүд харуулж байна.³ Иймд сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл, журмыг тодорхой болгох хэрэгцээ, шаардлага нийгмээс урган гарч буй агаад энэхүү асуудлыг юуны өмнө эрдэм судлалын хүрээнд судалсны эцэст улс төрийн практикт хэрэгжих үндэслэл бий болох юм. Иймээс энэхүү өгүүллэгээр төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох тогтолцоо буюу импичментийн асуудлыг онол, практикийн төвшинд авч судлах зорилгыг тавьснаас гадна манай иргэдийн энэ талаарх мэдлэг ямар хэмжээнд буйг судлахыг зорив.

Нэг: Импичментийн онол, сэтгэлгээний үндэс, олон улсад хэрэгжсэн туршилага

Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаа мөчирт хуваагаад, тэдгээрийг төлөөлсөн албан тушаалтнуудыг ард түмнээс сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулж хянадаг хариуцлагын тогтолцоог парламентат ёсонд “импичмент” (зэмлэл) хэмээн нэрлэдэг. Импичмент нь анх Англид үүссэн бөгөөд тус улсын парламент нь төрийн өндөр албан тушаалтнуудыг хариуцлагад татах импичментийн шүүхийг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй байдаг. Энэ тохиолдолд Нийтийн танхим шүүн таслах газар болдог бол Лордын танхим нь шүүхийн үүрэг гүйцэтгэдэг. 1376 онд Лорд Летимерийг авч хэлэлцсэн импичмент шүүх хамгийн эртний нэрд гарсан тохиолдол болсон бол сүүлийнх нь 1804 онд Хатан хааны тэнгисийн флотын өндөр албан тушаалтан Мэлвиллийг нярвын албан тушаалдаа хохирол учруулсан гэсэн үндэслэлээр импичмент шүүхэд татсан⁴ ажээ. Ийнхүү импичмент нь сонгодог утгаараа хоёр танхимтай парламент анх үүссэн Англид анх хэрэглэгдэж эхлээд дараа нь Английн төрийн тогтолцоог үндэслэл болгож өөрийн Үндсэн хуулийг боловсруулсан АНУ болон бусад улсууд улс төрийн практиктаа загвар болон хэрэглэж эхэлжээ. “1787 онд боловсруулж, 1789 онд албан ёсоор батлагдсан АНУ-ын Үндсэн хуулийг санаачлагчид нь Британийн имперээс цагаачлан ирэгсэд байсан бөгөөд Нэгдсэн Холбооны Улсын Үндсэн хуулийг хуучин эх орныхоо улс төрийн тогтолцоог дуурайлгахыг хүсэж, 1875 онд Франц улс XIX зууны Английн парламентын хаант ёсыг Бүгд найрамдах хэлбэр шинж болгосон лугаа адил 1787 оны Америк XVIII зууны Английн хэмжээт хаант засгийг Бүгд найрамдах хөрсөнд суулгажээ.”⁵

Орчин үед импичмент нь Их Британийн парламентын хувьд “унтаж буй” онцгой эрх мэдэл⁶ хэмээгддэг байна. Өөрөөр хэлбэл импичмент нь парламентын практикт бага хэрэглэгддэг. Тухайлбал АНУ-ын Конгрессын Сенатын танхим түүхэндээ 12 удаа импичментийн асуудлыг авч хэлэлцсэнээс ердөө дөрвөн хэрэгт л шийтгэл оноосон байна. Мөн Францын Үндсэн хуулиар парламентын дээд танхим болох Сенат нь импичментийн шүүхийн

² <https://www.legalinfo.mn/law/details/365>

³ Тэгээд ч Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн энэ хэсгийг Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон

⁴ Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 177 дахь тал. УБ., 2010

⁵ М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 201 дахь тал. УБ., 2007

⁶ Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 58 дахь тал. УБ., 2010

үүрэг гүйцэтгэх эрхтэй боловч улс төрийн практикт энэ эрхээ хэрэглэх тохиолдол гараагүй юм. Энэ нь импичментийн тогтолцоо тухайн улсын төрийн өндөр дээд албан тушаалтнуудын ёс зүй болоод улс төрийн хариуцлагатай байх явдалд шууд нөлөөлдөгтэй холбоотой.

Олон улсын практикаас үзэхэд парламентын доод танхим шүүхэд шилжүүлэх саналыг дэвшүүлж, дээд танхим уг хэргийг шүүх эрхтэй байдаг. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улсад Ерөнхийлөгч болон бусад төрийн дээд албан тушаалтнууд Үндсэн хууль зөрчсөн, эсвэл эрх зүйн шинжтэй алдаа гаргасан бол хариуцлагад татах тухай асуудлыг хэлэлцдэг. Ингэхдээ Төлөөлөгчдийн танхим импичмент үүсгэх тухай санал гаргана. Шийтгэл нь зөвхөн албан тушаалаас халах явдал бөгөөд эцсийн шийдийг Сенат гаргана. Шийдвэр гаргахын тулд танхим тус бүрийн гуравны хоёрын саналыг авсан байх ёстой.

Оросын холбооны улсын төрийн Дум нь Ерөнхийлөгчийг импичментийн асуудалд холбогдуулан яллагдагчаар татах онцгой бүрэн эрхтэй (энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд гуравны хоёрын санал шаардагддаг) бөгөөд Холбооны Зөвлөл нь Ерөнхийлөгчийн импичментийн асуудлыг хянах эрхтэй байдаг.

Тайланд улсад Төлөөлөгчдийн танхим болон Сенатын хамтарсан хуралдаанаар Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, Сонгуулийн хорооны гишүүд, Авилгыг эсэргүүцэх хорооны гишүүд, Улсын аудитийн хорооны ерөнхий аудитор болон гишүүд, Хүний эрхийн комиссын гишүүд, зэрэг төрийн өндөр албан тушаалтнуудыг импичмент үүсгэж огцруулах бүрэн эрхтэй.

Хоёр танхимтай парламентад ийнхүү импичментийн тогтолцоо үйлчилдэг учраас төрийн өндөр албан тушаалтнуудыг илүү хариуцлагатай, илүү ёс зүйтэй байх нөхцөл уруу түлхэж өгдөг. Бүхэлд нь дүгнэвэл хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн төрийн эрх мэдлийн байгууллагуудыг Үндсэн хууль болоод бусад хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж чадаж байна уу үгүй гэсэн хяналтыг хоёр танхимтай парламентын тогтолцоо илүүтэй хэрэгжүүлж чаддаг.

Хоёр:Төрийн өндөр албан тушаалтан огцруулах асуудал нь парламент, тэр дундаа хоёр танхимтай парламентын бүтэцтэй холбогдох ёстойг онолын хувьд тайлбарлах нь

Төрийн өндөр албан тушаалтнуудын эх сурвалж нь сонгуулийн зарчим байдаг учраас тэднийг огцруулах асуудал нь ярвигтай үйл явц байх нь дамжиггүй. Албан тушаалаас огцруулах шалтгаанууд нь эрх мэдлээ урвуулан ашиглах, ёс зүйн зөрчил гаргах зэргээр олон нийтийн итгэл хүндлэлийг алдсан үйлдлүүд юм. Ийнхүү хэн нэгэн албан тушаалтанг огцруулах асуудал нь намын хуваагдлаас гадна нийт иргэдийн дунд ч талцал маргаан үүсгэх нөхцөлийг бүрдүүлж болно. Тэрхүү талцал нь даамжирвал албан тушаалтанг огцруулах нь буруу зүйл хийсэн гэх хүчин зүйлээсээ хальж, аль хүчтэй, эрх мэдэлтэй талд шийдэгдэх эрсдэлийг ч дагуулна. Төрийн өндөр албан тушаал нь түүнийг эрхэлж буй хүнд олгосон итгэл, нэр хүндтэй холбоотой учраас маш эмзэг сэдэв байдаг. Иймээс энэхүү нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэж чадах цорын ганц институт бол сонгуулийн зарчмаар, тодорхой хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлдэг, ард түмний төлөөлөгчдийн байгууллага болох парламент юм.⁷ Учир нь албан тушаалаас огцруулах үйл ажиллагаа нь тухайн албан тушаалтанг үндэсний хэмжээнд буруу зүйл хийснийг нь шүүн хэлэлцэж буй үйл явц ажээ. Тэгвэл үндэсний хэмжээнд энэ асуудлыг ард иргэдийн төлөөллийг хэрэгжүүлэгч институт хариуцах нь зүйн

⁷ 1787 оны АНУ-ын Үндсэн хуулийн хуралдай энэ бүхнийг харгалзан үзээд төрийн өндөр албан тушаалтанг огцруулах санал гаргах эрхийг Төлөөлөгчдийн танхимд, харин эцсийн шийдвэр гаргах эрхийг Сенатад олгожээ. (The Federalist papers 65 - Objections to the Power of the Senate To Set as a Court for Impeachments Fur ther Considered. Alexander Hamilton)

хэрэг бөгөөд энэ тохиолдолд парламент хоёр танхимын бүтцээр зохион байгуулагдсан байх шаардлагатай.⁸ Энэ нь хоёр шийдвэрийг нэг байгууллага гаргах эрсдэлээс сэргийлж байгаа хэлбэр юм. Тухайлбал Төлөөлөгчдийн танхим огцруулах саналыг гаргаж, Сенат уг саналыг шүүн хэлэлцэж байгаа нь энэ хоёр институт бие биенийхээ гаргасан шийдвэрт харилцан хяналт тавих механизм болжээ.⁹ Тэгэхээр төрийн өндөр албан тушаалтан буруутай эсэхийг хэлэлцэх саналыг парламентын доод танхим гаргаж, албан тушаалаас огцруулах уу, үгүй юу гэх эцсийн шийдвэрийг шүүх болж хувирсан парламентын дээд танхим гаргах ажээ. Төрийн өндөр албан тушаалтанг шүүх маш хариуцлагатай энэхүү шүүн таслах ажиллагааг бие даасан, тогтвортой, гаднын нөлөөнд автахгүй хэрэгжүүлж чадах институт бол нийгмийн олон янзын эрх ашгууд дундаас сонгогдож болон томилогдсон, шигшмэл элитүүдээс бүрдсэн парламентын дээд танхим юм.

Гурав: Импичмент үүсгэх эрх бүхий парламентын мөрдөн шалгах хорооны тухай

Импичментийн асуудал яригдахтай зэрэгцэн парламентын “мөрдөн шалгах” хорооны тухай ойлголт гарч ирнэ. Энэ нь тусгай асуудлыг хянан шалгаж, шийдвэрлэхээр парламент дахь улс төрийн бүх намын төлөөллөөр байгуулддаг парламентын “мөрдөн шалгах хороо” юм. Судлаач Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт бүтээлдээ тус хороог “шүүн байцаан шинжих хороо”¹⁰ хэмээн нэрлэжээ. Тодруулбал хоёр танхимтай парламентын тогтолцоонд төрийн өндөр дээд албан тушаалтнуудад ипичментийн асуудлыг үүсгэх болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагаатай холбоотой бүх асуудлаар парламент бүрэн мэдээлэл авсан байх ёстой гэдэг зарчмаас үүдэн шүүн байцаан шинжих эрхтэй хороод ажилладаг. (Seleg Committee)¹¹

Тухайлбал АНУ-д¹² мөрдөн шалгах хороо нь онц эрхтэй байдаг бөгөөд тэрхүү эрхээ шаардлагатай үед эргэлзэх юмгүй хэрэглэдэг. Тус хороо нь зарлан дуудахаар хэнийг ч хуралд дуудах эрхтэйгээс гадна ирээгүй тохиолдолд торгож шийднэ. Мөрдөн шалгах хороо нь голдуу захиргааны асуудлыг байцаан шинждэг боловч уг чанартаа үйл ажиллагаа нь нэлээд өргөн буюу уг ажилд хамаарагдсан яам, албаны улс төрийн тэргүүн болон удирдлагатай холбоотой асуудлуудыг хянан шинждэг. Өөрөөр хэлбэл Конгрессын хороод мөрдөн байцаах эрх эдлэх бөгөөд энэ нь гүйцэтгэх засаглалыг далайцтай хянах, шүүмжлэх үүрэгтэй¹³. АНУ-ын Конгресс төрийн захиргааны байгууллагыг хянан шалгах эрхтэй, үүнд уг байгууллагыг үүсгэн байгуулах онцгой эрх болон үйл ажиллагааг нь тодорхойлох, санхүүгийн ажиллагааг нь хянах эрхтэй. Конгресс импичмент журамлалыг хэрэглэн шүүн таслах зарим эрх эдэлдэг нь холбооны ажилтан төрийн эсрэг ноцтой гэмт хэрэг үйлдсэн, тухайлбал урвасан, хээл хахууль авсан, төрийн хуулийг ноцтойгоор зөрчсөн хэргүүдийг шүүх эрхийг хэлж буй¹⁴. Төлөөлөгчдийн танхим санаачлан мөрдөн байцаах комисс байгуулж, комиссын дүгнэлтийн дагуу ял ногдуулах эсэхийг шийдэх шүүх болж хувирсан Сенатад шилжүүлэх бөгөөд Сенат

⁸ Төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцдог систем болох импичмент нь сонгодог утгаараа хоёр танхимтай парламент анх үүссэн Англид анх хэрэглэгдэж эхлээд дараа нь Английн төрийн тогтолцоог үндэслэл болгож өөрийн Үндсэн хуулийг боловсруулсан АНУ болон бусад улсууд улс төрийн практиктаа загвар болон хэрэглэж эхэлжээ. Өөрөөр хэлбэл импичмент нь хоёр танхимтай парламенттай улсуудад илүү нийтлэг, сонгодог байдлаар хэрэглэгддэг.

⁹ The Federalist papers 66 - Objections to the Power of the Senate To Set as a Court for Impeachments Fur ther Considered (Alexander Hamilton)

¹⁰ Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 162 дахь тал. УБ.,2014

¹¹ Тусгай асуудлыг хянан шалгаж, шийдвэрлэхээр парламентын гишүүдээс бүрдсэн хороо. Тус хороог парламент дахь улс төрийн бүх намын төлөөллөөр байгуулдаг. Ж.Төргөтх “Парламент судлалын гарын авлага” 190 дэх тал. УБ., 2010

¹² Мөн тэнд

¹³ М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 203 дахь тал. УБ.,2007

¹⁴ М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 204 дахь тал. УБ.,2007

хаалттай хурлаар хэргийг шүүнэ, шийтгэл нь гол төлөв албан тушаалаас нь огцруулах байдаг. Ингэхдээ Сенатын гишүүдийн гуравны хоёрын саналаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болно.¹⁵ Нэлээдгүй тохиолдолд парламентад төрийн дээд албан тушаалтны эсрэг хэрэг үүсгэх эрх олгодог. Тухайлбал Болгарын Үндсэн хуулийн дагуу парламент нь төрөөс төрөөс урвасан болон Үндсэн хуулийг зөрчсөн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийн асуудлыг шийдвэрлүүлэхээр эрхтэй байдаг.

Японд¹⁶ төрийн өндөр албан тушаалтан байцаан шинжих хорооны асуултанд хариулахаас татгалзсан тохиолдолд түүний учир шалтгааныг парламентад болон зохих яамдад тайлбарлах үүрэгтэй. Хэрэв 10 өдрийн дотор зохих яам хариу эс өгвөөс гэрчлэгч мэдүүлгээ өгөх ёстой байдаг.

Харин Герман улсад яг ийм тохиолдол гарвал холбогдох яамнаас зөвшөөрөл шаарддаг ба шаардаж буй мэдээллийг өгөхөд “Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах болон аюулд хүргэх, эсвэл улсын ажил алба гүйцэтгэхэд хүндрэлтэй болгох аваас яам хариу өгөхөөс татгалзаж болно” гэсэн байдаг. Парламентын мөрдөн шалгах хороо нь олон улсын практикт төдийлөн түгээмэл бусаар хэрэглэгддэг ба жишээ нь Норвеги, Финлянд, Швед зэрэг улсуудад ийм өндөр эрх хэмжээтэй хянан шалгах хороо байдаггүй. Зарим парламентын байцаан шинжих хорооны үйл ажиллагаа нь улс төрийн хяналтын гүйцэтгэх хүрээнээс халин гарч эрүүгийн хэрэг үүсгэхэд хүрдэг. Тухайлбал Италийн Үндсэн хуулийн 82-р зүйлд “Мөрдөн шалгах хороо нь шүүх эрх мэдлийн байгууллагатай ижил эрх, хязгаарлалтай шинжилгээ шалгалт явуулах эрхтэй” гэж заажээ.

Дөрөв: Төрийн өндөр албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох механизмын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэлд хийсэн судалгааны үр дүн

Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлтийн асуудал хүчтэй өрнөн буй энэ үед тус өгүүллэгээр хөндсөн импичмент болон парламентын мөрдөн шалгах хорооны талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл хэр байна вэ гэдэг дээр судалгаа хийж үзэв. Судалгаанд 35-60 насны эдийн засаг, нийгмийн ухаан, инженер, сэтгүүлч, багш зэрэг дээд боловсролтой, санамсаргүй түүврээр сонгогдсон нийт 40 хүн хамрагдав.

Судалгааны гол асуулт болох:


1. Өнгөрсөн 27 жилийн туршид төрийн өндөр дээд албан тушаалтнуудыг ард түмний зүгээс хянах, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог хэрэгжүүлж чадсан уу гэсэн асуултад судалгаанд хамрагчдын 90 хувь нь чадаагүй 10 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

¹⁵ Мөн тэнд


¹⁶ Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 162-163 дахь тал. УБ.,2014



2. Та төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох механизм болох импичментийн талаар мэдлэг мэдээлэлтэй юу? Гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын 15 хувь нь мэднэ, 30 хувь нь энэ талаар сонссон, 55 сайн мэдэхгүй гэж хариулжээ.



3. Та Парламентын мөрдөн мөрдөн шалгах хорооны талаар ямар мэдлэг мэдээлэлтэй вэ? Гэсэн асуултад 7 хувь нь мэднэ, 20 хувь нь сонссон, үлдсэн 73 хувь нь сайн мэдэхгүй гэж хариулжээ.



4. Харин төрийн өндөр албан тушаалтнуудад тооцох шаардлагатай юу гэсэн асуултанд 100 хувь шаардлагатай гэж хариулжээ.



Дүгнэлт

1. Импичмент болон парламентын мөрдөн шалгах хорооны талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл ийнхүү маш хангалтгүй байгаа нь энэ талын мэдлэг мэдээлэл зөвхөн эрдэм судлалын хүрээнд л яригддаг, судлагддаг, асуудал гэдгийг харуулж байна.
2. Төрийн өндөр албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцдог механизм Монголд ус агаар мэт хэрэгтэй байгаа нь дээрх асуулгын аргаар авсан судалгаагаар нотлогдож байна.
3. Засаглагчдын хяналтгүй эрх мэдлийг хязгаарлах оновчтой шийдэл нь парламентыг хоёр танхимд хувааж, төрийн өндөр дээд албан тушаалтнуудад хариуцлага тооцдог импичментийн тогтолцоог хэрэгжүүлэх явдал бөгөөд ингэснээр төрийн өндөр албан тушаалтнуудыг дур зоргоороо авирлах явдлыг таслан зогсоох боломж бүрддэг байна. Энэ талаар Францын судлаач Морис Дюверже, “Улс төрийн олон байгууламжийн дотроос зарим нь засаглагчдын эрх мэдлийг хязгаарлах, нөгөө хэсэг нь түүний эрх дархыг өргөжүүлэх хандлагатай байдаг. Засаглагчдын эрх мэдлийг хязгаарлах хамгийн үр дүнтэй арга бол улс төрийн байгууламжаар хязгаарлах арга юм¹⁷” хэмээн бичсэнийг санууштай.

¹⁷ М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 186 дахь тал УБ., 2007

Санал, зөвлөмж

Монгол пахь парламентын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчилж хоёр танхимтай болголоо гэхэд парламентын доод танхим нь төрийн өндөр дээд албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох импичментийг үүсгэх эрхтэй байх агаад доод танхимаас үүсгэсэн импичментийн асуудлыг дээд танхим хянан хэлэлцэх, шүүх эрхтэй байна. Ингэхийн тулд парламентын доод танхим санаачлан тусгай асуудлаар хянан шалгах эрх бүхий парламентын мөрдөн байцаах хороо байгуулах агаад тус хорооны дүгнэлтийн дагуу ял ногдуулах эсэхийг шийдэх шүүх болж хувирсан дээд танхимд шилжүүлэх бөгөөд дээд танхим хаалттай хурлаар хэргийг шүүх бөгөөд шийтгэл нь гол төлөв албан тушаалаас нь огцруулах явдал байх ёстой. Ингэхдээ парламентын дээд танхимын гишүүдийн гуравны хоёрын саналаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болно. Импичментийг зөвхөн төрийн өндөр албан тушаалтнууд болох Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, парламентын дарга, дэд дарга, парламентын гишүүд, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор зэрэг албан тушаалтнуудад хэрэглэнэ.

Abstract

We have discussed the jurisdictional authority of bicameral parliament on the accountability of high ranking state (senior) officials (impeachment), international practice of impeachment through bicameral parliamentary structure and the parliamentary inquiry committee and have studied the degree of public awareness and information on the system of accountability for senior officials in public administration

Ашигласан эх сурвалжууд

1. М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2007
2. “Улс төрийн шинжлэх ухаан” 40-41 дэх тал. УБ., 2001
3. Руссо, Жан Жак. “Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд” орч, Равдангийн Янжмаа УБ., 2002
4. Л. Өлзийсайхан “Парламент” УБ., 2001
5. Д.Сүхболд Бүгд найрамдахчуудгүй Бүгд найрамдах улс” МУИС “Политологи” сэтгүүл №13/ 442. 137 дахь тал. УБ., 2016
6. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 58 дахь тал. УБ., 2010
7. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 177 дахь тал. УБ., 2010
8. Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 60 дахь тал. УБ., 2014
19. Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 162 дахь тал. УБ., 2014
10. А.Юндэндорж, Ю.Атар “Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургааль” II-III дэвтэр Хөх хот 2003
11. “The Federalist papers” by Alexander Hamilton, James Madison, and John Jay. Introduction and Notes by Charles R.Kesler. Copyright 1961.
12. The Anti-Federalist Papers and the Constitutional Convention Debates. Introduction by Ralph Ketcham. 2003